

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”- ҮН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ГАРЧИГ		
1	НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2	ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
3	ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
4	ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
5	ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
6	ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
7	ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	24
8	НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах”-ын Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон Байгаль Орчин, Аялал жуулчлалын Яамны Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

“Магнай трейд” ХХК нь 1996 онд байгуулагдаж ОХУ, БНХАУ, Казахстан зэрэг орнуудаас нефть бүтээгдэхүүн импортлож, бөөний болон жижиглэнгийн борлуулалтын үйл ажиллагаа явуулж байна. Нөгөө талаар нефтийн бүтээгдэхүүн болон тос, тосолгооны материалыг нөөцлөх багтаамж ихтэй агуулахтай болж нефть бүтээгд

эхүүний дотоодын тээврийг өөрийн автобазад төвлөрүүлсэн автоцистернүүдээр гүйцэтгэж байна. Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлаж буй Нефть бүтээгдэхүүний агуулах нь 1998 оноос одоог хүртэл шатахуун болон түлшийг нөөцлөн хадгалж, хэрэглэгчдэд бөөнөөр борлуулалт хийж байна.

“Магнай трейд” ХХК нь нефть бүтээгдэхүүн, тос тосолгооны материалыг хэрэглэгчдэд шуурхай хүргэж чанартай үйлчилгээ үзүүлэх зорилготой ажилладаг.

- “МТ-Ойл” ХХК дотоодын зах зээл дээрх тос тосолгооны материал нийлүүлдэг бөгөөд нийт зах зээлийн 30%-ийг хангадаг.

- “МТ-Авто” ХХК нь “МТ групп”-ын шатахуун түгээх станцуудад нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх, автомашин засвар, угаалгын иж бүрэн сервис үйлчилгээ үзүүлдэг.

- Дээрхи компаниуд нь хүн амыг ажлын байраар хангаж Монгол улсын нийгэм эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгаа компаниудын нэг юм.

“Магнай трейд” ХХК нь нефть бүтээгдэхүүний агуулахаа стандарт нормын дагуу барьж байгуулан аваар осолгүйгээр чанартай нефтийн бүтээгдэхүүнийг өөрийн шатахуун түгээх станцууд, автомашин хэрэглэгчдэд түргэн шуурхай хүргэх үйл ажиллагааг явуулсаар ирсэн. Энэ хугацаанд байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон холбогдох захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, байгаль орчныг хамгаалах хөтөлбөрийг эрх бүхий мэргэжлийн компаниар боловсруулан Байгаль орчин аялал жуулчлалын яамаар баталгаажуулан хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Төслийн нэр:

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын нэр

“Магнай трейд” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011061082, регистрийн дугаар 2082489. МТ-Петролиум ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Дашням

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 6-р хороо НҮБ-ийн гудамж “Магнай трейд” ХХК-ний байр.

Утас: 93001010 Факс: 976-11-350005

Төслийн байршил

Нефть агуулах нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг, 22-ын товчооны зүүн талд байрлах бөгөөд 20,78 га талбайд үйл ажиллагаа явуулж байна. Тус нефть агуулахын зүүн талд нь “Жаст” ХХК-ийн нефть агуулах, урд талд нь “Багануур элч” ХХК-ийн нүүрс буулгах талбай тус тус байрлана.

Газар зүйн солбилцол нь $N47^{\circ}53'54,9^{11}$, $E106^{\circ}43'21,5^{11}$, $H=1254$ м



Зураг.1 Нефть агуулахын ерөнхий байршил /Google-ээс/



Зураг.2 Газрын тосны агуулахын харагдах байдал



Зураг.3 Автоэстакад



Зураг. 4 Төмөр замаас буулгах эстакад

Нийслэлийн засаг даргын захирамжаар 2082489 дугаар гэрчилгээ бүхий 4.97 га талбайтай газар эзэмшдэг.

Төслийн хүчин чадал, үйл ажиллагаа

Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Газрын тосны бүтээгдэхүүний агуулах нь ТС-1, А-80, АИ-92, АИ-95, АИ-98 Дизель түлш болон бусад тос тослох материал хадгалан Улаанбаатар хот, орон нутагт орших шатахуун түгээх станцуудыг нефтийн бүтээгдэхүүнээр хангах үйл ажиллагаа явуулдаг.

Нефть бүтээгдэхүүний агуулахын савны хүчин чадал

Хүснэгт.1

Байршил	Савны дугаар	Шатахууны төрөл	Савны төрөл	Савны хэмжээ м ³	Савны тоо ширхэг	Нийт багтаамж м ³
Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт хуучин 22-ын товчооны наана	1	ТС-1	босоо	2000	1	2000
	2	А-80	босоо	2000	1	2000
	3	Аи-92	босоо	2000	1	2000
	4	ДТ	босоо	2000	1	2000
	5	ЕвроДТ	босоо	2000	1	2000
	6	Аи-92	босоо	2000	1	2000
	7	ДТ	босоо	5000	1	5000
	8	Аи-92	босоо	5000	1	5000
	9	Аи-92	босоо	5000	1	5000
	10	ДТ	босоо	5000	1	5000
	11	А-80, Аи-95, Аи-98	Хэвтгээ сав		100	22
Нийт					32	34200

Тус нефть агуулах нь сардаа бүх төрлийн нефть бүтээгдэхүүнийг 8000 гаруй тонныг импортлодог. Нефть агуулах нь дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Үүнд:

1. 16 вагонцистерний зогсоолтой 5 төрлийн бүтээгдэхүүн 16 байраар хүлээн авах болон 4 төрлийн бүтээгдэхүүн 2 байраар вагонцистернд ачих хүчин чадал бүхий вагон эстакадтай
2. 5 төрлийн бүтээгдэхүүн 10 байраар автоцистернд ачих зориулалттай Германы FMC компаний автомат тоолуураар тоноглогдсон ачих эстакадтай
3. Вагонцистернээс резервуар парк руу, резервуар паркаас вагонцистерн рүү, резервуараас резервуарт шилжүүлэн шахах зориулалттай 160 м3/цаг хүчин чадал бүхий CYZ-A-150 маркийн 6 ш насостой дамжуулах хэсэг, 5 төрлийн бүтээгдэхүүн 10 байр луу шахах зориулалттай 80 м3/цаг хүчин чадал бүхий CYZ-A-80 маркийн 10 ш насостой шахах хэсэг, резервуар дахь бүтээгдэхүүнийг хянах, хэмжих зориулалттай ENRAFы удирдлага хяналтын тоног төхөөрөмжийн хослол бүхий насос станцтай
4. Резервуар паркийн ууршилтын алдагдал болон галын аюулаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий 1000 м3-ийн багтаамжтай галын усан сантай
5. Нефть агуулахын үндсэн технологийн үйл ажиллагаа явагддаг хэсгүүдээс үйлдвэрлэлийн болон хур тунадасны бохир ус зайлуулан ялгах бохирын системтэй
6. Дотоод хэргцээнд зориулсан зөөврийн ШТС-тэй
7. Хяналтын камертай
8. Шалгах байр
1. Тус нефть агуулахад нийт 36 ажиллагсадтай ба 7 хүн нь ээлжээр ажилладаг.

Барилга байгууламж жагсаалт

Хүснэгт.2

д/д	Ачих буулгах байгууламжийн хийц тоног төхөөрөмжийн хийц тоног төхөөрөмж элемент		Хэмжих нэгж	Тодорхойлолт, үзүүлэлт хүчин чадал	
1.	Буулгах байгууламжийн үндсэн бүрэлдэхүүн	Шат, тавцан /тоо урт/	ш/м	шат-2ш, 12.2 метр тавцан –ш, 90 метр	
		Коллектор	Байгаа эсэх	Байгаа	
		Гэрэлтүүлэг /тоо, хүчин чадал/	ш/вт	7ш, 16500 вт	
		Шүүр тунгаагуур газардуулга	Ш	22	
			Байгаа эсэх	Байгаа	
2.	Коллектор	ДТ	Диаметр	Мм	110,150
			урт	М	88.6
		Автобензин	Диаметр	Мм	100,150
			урт	М	177.2
		Тос	Диаметр	Мм	100
	урт	М	4		
3.	Нэг удаа хүлээж авах хүчин чадал вагонцистерн		тоо	16 вагонцистерн	

4.	Буулгах ачих хэрэгсэл	марк			150 CYZ-A-55, 80CYZ-A-32 АСВН-80
		Буулгах хоолойн диаметр автоцистерн вагонцистерн		мм	75 100
		тоо		ш	42
		Буулгах байгууламжийн төрөл - Вагонцистерн дээгүүр буулгах ачих - Автоцистерн доогуур буулгах ачих			- Вагонцистерн дээгүүр буулгах ачих - Вагонцистерн доогуур буулгах ачих - Автоцистерн дээгүүр буулгах ачих
5.	Чанарын шинжилгээний лабораторитой эсэх				байгаа
6.	Насос станц	Хүлээн авах насос	Тоо	Ш	6
			Төрөл марк	Модель	150CYZ-A-55
			Хүчин чадал	м ³ /ц	160
		Ачих насос	Тоо	ш	15
			Төрөл марк	Модель	80CYZ-A-32, АСВ-80
			Хүчин чадал	м ³ /ц	50,30
7.	Сав	Үйлдвэрлэсэн улс			ОХУ БНХАУ
		Тоо		ш	100м ³ -22ш, 2000м ³ -6ш, 5000м ³ -4ш
		Багтаамж		м ³	34200
		байршил		Ил далд	ил
8.	Талбайн гэрэлтүүлэг	Тэсрэлтээс хамгаалалттай прожектор		Тоо	7ø
				Хүчин чадал вт	16500 вт
		Суурин		Тоо	7ш
				Хүчин чадал вт	16500 вт
9.	Шатахууны шугам хоолой	Урт	А-80	М	787
			А-92	М	1076
			ДТ	М	995
			ТС-1	М	433
		диаметр	А-80	Мм	216,159,108,89
			А-92	Мм	159,108,89
			ДТ	Мм	159,108,89
			ТС-1	Мм	159,108,89
10.	Автоцистернээс буулгах талбайн тодорхойлолт	Тэгш талбай		Байгаа эсэх	байгаа
		Газардуулга		Байгаа эсэх	байгаа
		Урт		М	4м

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	Шүүр тунгаагуур	Ш	1ш	
11.	Төмөр замын салааны урт/ зөвхөн вагон эстакад/	м	Нэг замын урт 102 м, нийт 204 метр төмөр зам	
12.	Ачих буулгах ажиллагааны удирдлага	хэлбэр	автомат	
13.	Ачих буулгах байгууламжийн тоо, хүчин чадал	Тоо/м	10ш, 500м ³ /ц	
14.	Гал унтраах багаж тоног төхөөрөмж	Усан сан	м ³ , тоо	1000
		Хөөсний нөөц	м ³	4-5
		Хөргөлтийн систем	Байгаа эсэх	байгаа
		Аваарын дохиолол	Байгаа эсэх	байгаа
		Хөөсний систем	Байгаа эсэх	байгаа
		Галын анхан шатны багаж хэрэгсэл	%	100
15.	Хашааны тухай тодорхойлолт		Төмөр бетон хавтан	
16.	Сав паркийн далангийн тодорхойлолт		Хатуу хучилттай	
17.	Савласан бүтээгдэхүүнийг хадгалах саравчтай талбай бүтээгдэхүүн агуулахтай эсэх		40 тонны 15ш контейнертэй	
18.	Цуглуулах, ууршуулах, цэвэрлэх байгууламжтай эсэх		байгаа	
19.	Ослын сав		25м ³ хэвтээ сав	
20.	Холбоо		Бүх төрлийн холбоо хангалттай	

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Магнай трейд”-ын удирдлага, ажилчид болон байгууллагын байгаль орчин хариуцсан мэргэжилтэнгүүд хөрсийг бохирдуулахаас бүх талаар сэргийлж, бүтээгдэхүүнийг асгаж гоожуулахгүй байх бүх боломжит арга хэрэгслүүдийг хэрэглэж хүн бүрийг энэ талаар мэдлэгтэй байлгаж байна.

Агаарын бохирдлыг бууруулахад боломжит бүх хувь нэмрээ оруулж бүтээгдэхүүнийг хэрэглэж буй автомашинаас гарах утаа нь агаарын бохирдолд ихээхэн нөлөө үзүүлэх учраас бид аль болох чанартай, бүрэн шатах, хорт утааны агууламж багатай шатахууныг импортолж байна.

Хүснэгт.3

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөнүүд	Сөрөг нөлөөллийг арилгах,бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	БИЕЛЭЛТ
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаар	<ul style="list-style-type: none"> Ачилтын байр болон буулгах байрны техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах. 	Ажлын байрны агаарын бохирдлын хэмжээг хянах, агаарын чанарыг хамгаалах	ш	Дотоод зардлаар	Байнга	Дотоод зардлаар	Жил	ГТБА-ын хэвийн ажиллагаа болон шугам хоолойн битүүмжлэлийг хийж агаарт ууршихаас урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.
		<ul style="list-style-type: none"> Савны битүүмжлэлийг хангах Сав тоног төхөөрөмж, шугам хоолой, 		төг	500,0	1	500,0	2022 он	Шатахуун нөөцлөх савны битүүмжлэлийг хангаж нефтийн бүтээгдэхүүн агаарт алдагдахаас урьдчилан сэргийлсэн
		<ul style="list-style-type: none"> Шатахуун хадгалах савны амьсгалах хоолойн хэвийн үйл ажиллагааг хангах 		Тогтмол	Дотоод зардлаар	Байнга	Дотоод зардлаар	2022 он	Шатахуун хадгалах савны амьсгалах хоолойн хэвийн үйл ажиллагааг хангаж өдөр тутам шалгаж ажилласан
2	Хөрс, ургамал	<ul style="list-style-type: none"> Шатахууныг тээвэрлэх, хадгалах, түгээх үйл ажиллагааны үед бүтээгдэхүүн асгарч орчныг бохирдуулсан 	Шатахууны хэвтээ сав парк	төг	21,00,000	3	63,000,000	2022 онд	ГТБА-ын үйл ажиллагааны явцад шатахууны асгаралт, осол аваар гарч БО-н хөрсийг бохирдуулж сөрөг нөлөө үзүүлээгүй Савны бүрэн бүтэн байдлыг

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		нөхцөлд нэн яаралтай арга хэмжээ авах төлөвлөгөөтэй, хоргүйжүүлэх зааварчилгааг холбогдох хүмүүст өгч ажиллах.							хангаж ажиллах зорилгоор 2ширхэг 2000м3 хэвтээ 10ширхэг 100м2-ийн саванд метал хийцийн шинжилгээ хийж, савыг цэвэрлэсэн
		<ul style="list-style-type: none"> Асгарсан шатахууныг нэвчээж авах зорилгоор элс, хужир бэлдэх 	Зам талбай	Төг	250,0	Жил	250,0	Байнга	Хатуу хучилттай шатахуун буулгах талбай, болон шатахуун ачих түгээх явцад дусаж хэсгүүдийг хужир, элсээр цэвэрлэх арга хэмжээг авч ажилласан
		<ul style="list-style-type: none"> Зам талбайн эвдрэл гэмтлийг засварлан замын тэмдэг тэмдэглээ хийж засварласан. 	Зам талбай авто зогсоол	төг	300,0	2022 онд	300,0	2022 онд	ГТБА-ын зам, болон талбайн эвдэрсэн зам талбайг засварлан нөхөж бетон хучилт хийж хөрс, усыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.
3	Газрын доорх ус	<ul style="list-style-type: none"> Усыг гамтай хэрэглэх, хэрэглээний усыг эргэлтээр ашиглах талаар судалгаа хийж, боломжит хувилбарыг нэвтрүүлэн, хяналттай ажиллах. ундны усанд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан үзүүлэлтээр шинжилгээ хийлгэх. 	ГТБА-ын төв байр	Төг	600,0	-	600,0	2022 онд	Тус ГТБА нь унд ахуйн хэрэгцээний усыг нэгдсэн ус хангамжийн худаг болон 20литрийн савалгаатай цэвэршүүлсэн ус зөөврөөр авч хэрэглэдэг тул эрүүл ахуйн шаардлага бүрэн хангадаг. ГТБА нь бохир усны цооног буюу 40-тн төмөр сав суурилуулан бохир усыг соруулан зайлуулдаг.
		<ul style="list-style-type: none"> Шинээр орж буй ажилчдад тусгайлан сургалт явуулах. Нийт ажилчдад 							<ul style="list-style-type: none"> Шинээр орж буй ажилчдад байгаль орчин, аюулгүй ажиллагааны

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

4	Ард, иргэд ба ажилчид	<p>ажиллах зааварчилга, сануулгыг өдөр тутам өгч байх.</p> <ul style="list-style-type: none"> Аюулгүй байдлын хангах үүднээс ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах. 	ГТБА-ын ойр орчимд	Төг	4,100,0	4	16,400,0	2022 онд	<p>зааварчилгааг өгч сургалт явуулдаг.</p> <ul style="list-style-type: none"> Өдөр тутмын зааварчилгааг өглөө ажилд гарахаас өмнө өгдөг. Ажилчдад жил бүр өвөл зуны нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсаар хангадаг.
5	Гал түймэр аюулаас	<ul style="list-style-type: none"> Аянга зайлуулагчийг батлагдсан зураг төслийн дагуу шаардлагатай хэсгүүд дээр хийж байрлуулсан байх; Техник тоног төхөөрөмж бүгд газардуулагатай байх, газардуулгын ажиллагааг ялангуяа хавар, намар шалгаж байх. Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгслэлээр хангаж, байнга бэлэн байдалд байлгах 	ГТБА-ын хэмжээнд	Төг	9,000,0	-	9,000,0	2022 онд	<ul style="list-style-type: none"> ГТБА-ын стандарт нормын дагуу аянга зайлуулагч суурилуулсан. Жил бүр аянга зайлуулагч, тоног төхөөрөмжүүдийн газардуулгын эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж протокол гаргуулдаг. Галын анхан шатны багаж хэрэгслийн үзлэг шалгалтыг тогтмол хийж, даралт нь унасан галын хор болон шаардлага хангахгүй болсон багаж хэрэгслүүдийг шинчилж бүрэн бүтэн байдлыг хангаж галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.
	Нийт						90,050,000		

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт.4

№	Орчны тохижилт,цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүй баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг арилгах, багасгах арга хэмжээ авсны дараа үлдэж байгаа нөлөөллийг арилгах	Шороон болон эвдэрсэн зам талбайг засварлах	ГТБА			Хөрөнгө оруулалтаар		2022	Тус ГТБА-ын зам, талбай засварын ажлыг хийж гүйцэтгэн хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.
2	Зам талбай, ачих байрны гэрэлтүүлэг	Ачих байрны иж бүрдэл	ГТБА			Хөрөнгө оруулалтаар		2022	Гэрэлтүүлгийг сүүлийн үеийн цахилгааны хэмнэлт бүхий ЛЕД гэрэл суурилуулж, Байгалийн нөөцийг зөв захистой ашиглах. Хотын өнгө үзэмжийг сайжруулах
4	Тохижолт өнгө үзэмжийг сайжруулах	ГТБА	ГТБА			Хөрөнгө оруулалтаар		2022	ГТБА-ын самбар, ачилтын байр, замын хашлагуудыг будаж ГТБА болон хотын өнгө үзэмжийг сайжруулах арга хэмжээг авсан.
ГТБА-ын газрын өнгө үзэмжийг сайжруулж, барилга, насос станц, худгийг бүрэн будсан.									
6	Байгалийн нөөц баялагийн зөв захистой хэрэглээ	ГТБА	ГТБА			Хөрөнгө оруулалтаар		2022	Тус ГТБА-ын лабораторийн сорьц болон дээжний шинжилгээний шинэ багаж төхөөрөмж авч шинэчлэсэн
	Нийт			Төгрөг					

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.5 Хөрс, ус, агаарын дээж болон шинэчилсэн аюулгүй ажиллагааны самбар



Зураг.6 Агуулахын дотор болон гаднах замын тэмдэг тэмдэглэгээ, авто машины зогсоолын тэмдэг зураас

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.7 Дүүргийн онцгой байдлын албатай хамтарч гамшиг ослын тактикийн сургалт хийсэн



Зураг.8 Агуулах доторх ногоон байгууламж

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.9 Аюул эрсдэлдийн бэлэн байдлыг хангах үүднээс галын багаж хэрэгслийг бүрэн шинчилж, гаднах өнгө үзэмжийг сэргээсэн



Зураг.10 Аюул эрсдэлдийн бэлэн байдлыг хангах үүднээс даралт унасан, ашиглах боломжгүй галын хорнуудыг бүрэн шинчилсэн

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.11 Технологийн шугам хоолой болон эд ангиудын насжилтыг нэмэгдүүлэх өнгө үзэмж сайжруулах бүдгийн ажил



Зураг.12 Хэвтээ саванд шатахуун авах 3 насосыг вакум насосоор сольж агаарын бохирдол багасгаж, насосны битүүмжлэлийг сайжруулав

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.13 Босоо савнаас шатахуун ачих завсрын шугам хоолойн коллекторын шүүрийг бүрэн шинэчилж шинээр сольсон



Зураг.13 Хэвтээ болон босоо саванд цэвэрлэгээ хийж, метал хийцийн шинжилгээ хийсэн

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.14 Агуулах чанартай бүтээгдэхүүн худалдах үүднээс итгэмжлэгдсэн лабораторит орчин үеийн шинэ багаж худалдан авсан

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.15 Агуулахын хашаан доторх болон гадна талын ойр орчмын талбайг цэвэрлэж, зохих ёсны хогийн цэг дээр өгөв



Зураг.16 Аюулгүй байдлын үүднээс агуулахын хашаан доторх зэрлэг өвсийг хадаж зохих ёсны дагуу хогийн цэг дээр өгөв

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг.17 Агуулахын цахилгаан шитны байрны хууларсан дээврийг засварлаж ус гоожих аюулаас урьдчилан сэргийлсэн



Зураг.18 Нөөцийн элс, хужир

ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 онд тус ГТБА нь Сонгинохайрхан дүүргийн сууришлын бүсэд байрладаг ба тус онд үйл ажиллагаа хэвийн явагдсан бөгөөд шинээр барилга байгууламж барьж, газар шорооны ажил явагдаагүй тул түүх соёлын өв ГТБА-ын талбайгаас олдох болон сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болно.

ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“МТ Петролиум” ХХК нь ажилчид болон харилцагч, хэрэглэгч нарын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах нь урт удаан хугацааны ХАБЭА-н үүрэг бөгөөд манай соёл байх болно. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, цаашид тогтвортой хэрэгжүүлэхийн тулд компанийн дотооддоо мөрдөх журам, түүнийг даган гарсан заавар, зааварчилгааг шинээр боловсруулан мөрдөж байгаа бөгөөд хүн бүр ажиллалаа аюулгүй гүйцэтгэх арга барилд байнгын суралцаж, орой бүр гэр бүлдээ эсэн мэнд харих нөхцлийг бүрдүүлж байна.

Хүснэгт.5

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлээс үүдэн түлш шатахуун асгарах, гал гарах	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	ГТБА-ын хэмжээнд		Төг	-	Байнга	Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль, заалт 4.2, заалт 2.10, заалт 6.1.2, зүйл 8; зүйл 9; заалт 10.1; зүйл 12; зүйл 14; заалт 15.1; заалт 16.1, заалт 16.2, заалт 16.3 Галын аюулгүй байдлын тухай хууль, заалт 16.1, заалт 18.1, заалт 19.1, заалт 20.1, заалт 21.1 хангаж ажилласан
3		Түлш, шатахуун хадгалах шилжүүлэн ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх				-	Өдөр бүр	
4		Шатахуун асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл цэвэрлэгээний материал бэлтгэж бэлэн болгох				1,000,0	Жилд 1 удаа	
5		Аваар ослын үед битүүмжлэл алдагдаж асгарсан, нефтийн бүтээгдэхүүнийг (НБ) яаралтай хутган				250,0	Тухай бүрт	

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		авч савлаж, битүүмжлэх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээг яаралтай авах					
6		Газар ашиглалт, газар зохион байгуулалтыг сайжруулах, хяналт шалгалт тогтмол хийх, ажилтан албан хаагч нарт дотоод журам танилцуулах				-	Тухай бүрт Газар эзэмших гэрчилгээнд заагдсан газрын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, эзэмшлээс өөр газарт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээг авч ажилласан.
	Нийт					1,250,0	

ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ГТБА-ын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын менежментийг сайжруулахад хүний хэрэгцээ өсөн нэмэгдэхийн хэрээр түүнийг дагасан хог хаягдал гарч байдаг бөгөөд хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулахаас эхлэн дахин ашиглах байдлаар хог хаягдлын менежментийг тогтвортой хэрэгжүүлж, эрчим хүчний ашиггүй хэрэглээг бууруулах мэдлэгтэй байлгаж, мөн орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн эрчим хүчний үйлдвэрлэл, дэлхийн дулааралд нөлөөлөх байдалд хувь нэмэр оруулсаар ирсэн.

Хүснэгт.6

№	Хог хаягдлын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Агуулга	Хог хаягдлыг цэвэрлэх байгууламж, төхөөрөмж	Тайлбар
.	Шатахууны алдагдлаас гарсан хаягдал			Урьдчилан тооцоолох боломжгүй, технологийн горим чанд баримталж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаснаар шатахуун алдагдахгүй	Ослын саванд хуримтлуулаж зохих журмын дагуу устгана.	2022 онд ямар нэгэн осол аваар гараагүй тул нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хог хаягдал гараагүй болно.

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2.	Ахуйн гаралтай хог хаягдал	тн	4	Хоол хүнсний сав баглаа боодол гэх мэт ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний хаягдал	Зориулалтын хогийн саванд хуримтлуулж нийслэлийн нэгдсэн хогийн цэгт хаяна.	ГТБА-ын үйл ажиллагааны явцад гарсан хог хаягдлын дүүргийн тохижолт үйлчилгээний компанитай гэрээ байгуулан сар бүр ачуулж зайлуулдаг.
3.	Ахуйн бохир /бие засах газар/	тн	180	Төв байрны бохирыг зориулалты саванд цуглуулан соруулах	Бохирын цооног	Төв байрны бохирыг зориулалты саванд цуглуулан соруулж, Зориулалтын саванд хуримтлуулсан бохирыг хлорминаар байнга ариутгалыг хийсэн.
4	Ахуйн хог хаягдал	Ш	4	Хог хаягдлыг ангилан ялгах	Шаардлагатай газруудад	ГТБА-ын үйл ажиллагаанаас гарсан ахуйн гаралтай хог хаягдлын ангилан ялгах арга хэмжээний хүрээнд нэмэлтээр хогны сав шинээр авч байршуулсан.

ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт.7

№	Хяналт шинжилгээний хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн Тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	тайлбар	Баримтлах стандарт, арга,аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	АГААРЫН ЧАНАР	<p><u>Хянах зүйл:</u> PM10, NO, NO₂, NO_x CO, SO₂, HC_{нийт}, CH₄, дуу чимээ</p> <p><u>Хяналтын цэгүүд:</u> Энэ цэгүүдийг ажлын бүсэд урьдчилж тогтоосон байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байр - Салхины зонхилох чиглэлийн доор 100 м-т - Нефтийн бүтээгдэхүүн хадгалах болон түгээх байгууламж болон нөөцлүүр савны ойролцоо 	Үйл ажиллагааны явцад жилд 1 удаа	2	50,0	100,0		
2	ГАЗРЫН ДООРХИ УСНЫ ЧАНАР, НӨӨЦ	<p><u>Хянах зүйл:</u> Усны чанарын үндсэн үзүүлэлт, рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO₃), Ca, Mg, Na, K, SO₄, NH₄, Fe, өнгө, үнэр, азотын төрлийн бодис (нитрит, нитрат), бактериологи, усан дахь хүнд металлын шинжилгээ</p> <p><u>Хяналтын цэгүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Суурингийн ундны усны ус хангамжийн хяналтын цооногууд 	Үйл ажиллагааны явцад жилд 1 удаа	2	47,0	94,0		

3	ХӨРС	<p><u>Хянах зүйл:</u> Хөрс бохирдуулагч элементүүд, нефтийн бүтээгдэхүүн, хүнд металл, шим буюу азотын бохирдолт</p> <p><u>Хяналтын цэгүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> - ГТБА-ын буулгах ба түгээх талбай 2 цэг - Үйлдвэрийн орчинд холбогдох мэргэжилтний сонголтоор 2 цэг тогтоож - Бүх машин механизм, тээврийн хэрэгслэлийн зогсоолууд 	Үйл ажиллагааны явцад жилд 1 удаа	2	56,0	112,0		
	Нийт					306.0		

НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэл өндөртэй аюулын тоог бууруулж, хяналтандаа авч, өндөр эрсдэл бүхий ажил, ажлын байруудад байнгын шинжилгээ хийж хүн бүр хяналтандаа байлгаж, ажлын байран дахь ослын тоог бууруулахын тулд аюулыг мэдээлэх хуудсаар осолд дөхсөн тохиолдол болон аюул үүсэх нөхцлүүдийг урьдчилан харж, тохирох залруулах болон сэргийлэх арга хэмжээг байнга авснаар осол гаргахгүй ажиллах нөхцөл бүрдүүлж, ослоос үүсэх хүн өдрийн алдагдлыг бууруулахын тулд хүн бүр өөрийн болон хамт ажиллаж буй хүний аюулгүй байдалд анхаарч ажилласнаар хөдөлмөр өдрийн алдагдлыг бууруулж, аливаа гэстлээс урьдчилан сэргийлж чадлаа.

Мөн сургалтын цагийг нэмэгдүүлж, ХАБЭА-н соёлтой хамт олон байх болно сургалтуудыг шат дараалуулан байнга зохион байгуулж аюулыг харж чадах чадамжийг хүн бүрт эзэмшүүлж ирсэн.

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт.8

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь 2020 он			Хариуцсан албан тушаалтан	Биелэлт
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	8
1	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгах.	100,0				ГХХБОАА инженер	Байнгын бэлэн байдлыг хангаж ажилласан
2	Нийт ажилчдыг байгаль орчныг хамгаалах талаар сургалтад хамруулах	Дотоод зардлаар	1 сард			ГХХБОАА инженер ХАБЭА инженер	Нийт ажилтны сургалт
4	БОМТөлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих, БОМТөлөвлөгөөний гүйцэтгэлийг заасан хугацаанд нь холбогдох байгуулагад хүргүүлж, тайлагнаж байх.	-	2022			Салбарын дарга	
5	Засаг даргын тамгын газраас зохион байгуулж буй бүх нийтээр хог цэвэрлэх, мод тарих, хур хог хаягдлыг зайлуулах ажилд идэвхтэй оролцож нийслэл дүүргийн байгаль орчин болон өнгө үзэмжинд хувь нэмэр оруулах.	1,200,0	Тухай бүрт нь	Тухай бүрт нь	Тухай бүрт нь	ГХХБОАА инженер	ГТБА-ын өнгө үзэмжийг сайжруулах, ойр орчмын 50м зам талбайг тогтмол цэвэрлэдэг.
Нийт		1,300,0					

ГТБА-ын ажилчдын ажлын байрны аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцүүлэн хангах арга хэмжээг хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлж, хортой нөхцөлд ажиллаж буй ажилдаа хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангаж, жилд 1 ажилтанд 403,200 төгрөгний хор саармагжуулах бүтээгдэхүүн олгодог бөгөөд нийт ГТБА-д ажиллаж байгаа 36 ажилчдад **14,515,200** төгрөг зарцуулсан.

Үүнээс гадна ажлыг тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, ажлын тусгай хувцасны чанарын үзүүлэлтийн стандарт MNS 6231-2011 баримтлан эдэлгээний хугацааг тогтоож ажлын хувцсаар байнга хангаж байгаа ба ГТБА-ын нийт ажилчдыг өвөл, зуны хувцасаар хангахад нийт **18,900,000** төгрөг зарцуулсан. Тус агуулахын нийт ажилчдад улирал бүр хөдөлмөр хамгааллын даавуун бээлий, резин бээлий, гар нүүрийн алчуур, саван, чийдэн зэргээр хангадаг. ГТБА-ын нийт ажилчдыг хөдөлмөр хамгааллын зүйлээр хангахад жилд нийт **12,000,000** төгрөг зарцуулсан.

Эрүүл мэндийн газартай хамтарн нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж **3,528,000** төгрөг зарцуулсан.

ГТБА-ыг хариуцаж буй мэргэжилтэн ашиглалтанд орсон цагаасаа эхлэн байгаль орчинд ээлтэй, аваар осолгүй ажиллах, байгаль орчны багц хуулиудад заагдсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлж үйл ажиллагаагаа тогтмол явуулж ирсэн бөгөөд Байгаль орчныг менежментийн төлөвлөгөө /БОМТ/, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт /ОХШХ/ тусгагдсан арга хэмжээнүүдийг заагдсан хугацаанд нь хэрэгжүүлж, орчны мониторингийн судалгаа, шатахуун буулгах, хадгалах, түгээх явцад хөрсөнд алдагдах, нефтийн бүтээгдэхүүний ууршилтаас агаарт дэгдэх хорт бодис зэрэг шаардлагатай судалгаа шинжилгээг цаг хугацаанд нь хийлгэж ирсэн.

Сөрөг нөлөөллөөс урдчилан сэргийлэхийн тулд агаар, хөрсний бохирдолт, технологийн буруу үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг засварлан, сул талбайг зүлэгжүүлж, ногоон бүс бий болгон, тэмдэг тэмдэглэгээний дагуу тээврийн хэрэгслүүдийг явуулж, ГТБА-ын тоног төхөөрөмжийн сэргээн засварлах ажлуудыг хийж, ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж холбогдох байгууллагатай гэрээ хийн ажиллаж ирлээ. Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны бүрэн үзлэгт хамрагдаж галын аюулгүй байдлын дүгнэлтийг нийслэлийн онцгой байдлын газраас жилд 1 удаа авдаг **1,000,000** төгрөг.

“МАГНАЙ ТРЕЙД” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ”-ЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ГАРЧИГ		
1	НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
2	ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
3	ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
4	ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
5	ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
6	ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
7	ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	23
8	НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24